

ХААН Банкны хамтарсан санхүүжилт

Улс:	Монгол
Төслийн дугаар:	43875
Бизнесийн салбар:	Банкуудад олгох зээл
Төрийн/Хувийн:	Хувийн хэвшил
Байгаль орчны ангилал:	Санхүүгийн байгууллага
Захирлуудын зөвлөлийн огноо:	2012 оны 4 сарын 17-ны өөдр
Статус:	Бүтцийн хяналт хийгдсэн, Захирлуудын зөвлөлөөр хэлэцэгдээгүй
Төслийн хураангуй нийтлэгдсэн огноо:	2012 оны 3 сарын 13-ны өдөр

Төслийн танилцуулга

ЕСБХБанк Нидерландын Хөгжлийн Банк-тай (FMO) хамтарч А/В зэрэглэлийн хамтарсан санхүүжилтийг ХААН Банк-д олгохоор судалж байна. Монгол улсын эдийн засаг болон хувийн үйлдвэрлэлийн салбар дахь бизнесийн хүчтэй өсөлттэй үед дунд болон урт хугацааны нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр шаардагдаж байгаа ба энэ нь тус зээлийн санхүүжилтээр олгогдох юм

Шилжилтийн үйл явцад үзүүлэх нөлөөлөл

Төслийн шилжилтийн үйл явцад нөлөөлөх нөлөөлөл нь бүс нутаг болон орон нутгийн үйлдвэрлэлийн салбарт илүү урт хугацааны санхүүжилт олгосноор зах зээлийн өсөлтийг дэмжихэд оршино. Тус төсөл нь ХААН Банкны гадаад валют зээлдүүлэх үйл ажиллагаа, ийм төрлийн зээлтэй холбоотой эрсдэлүүдийг тогтоосноор бусад банкнуудад бизнесийн ёс зүйн өндөр стандарт тогтоох үйл ажиллагаануудыг дэмжинэ. Энэ санхүүжилтийн хамтарсан бүтэц нь тус улсын банкны системийн хувьд шинэлэг зүйл бөгөөд энэ нь тус салбарын үйл ажиллагааг санхүүжүүлэх шинэ арга замуудыг нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Харилцагч

ХААН Банк бол Монгол улсын зах зээл дээрх хамгийн том арилжааны банк бөгөөд дотоодын зах зээлийн нийт хөрөнгийн 24%, зээлийн багцын 27%-ийг тус тус эзэлдэг. Тус банк нь орон даяар нийт 499 салбар, дэд салбаруудтай хамгийн том ба орон нутагт тархсан сүлжээ банк юм. Мөн тус банк Монгол улсын нийт айл өрхүүдийн 80%-д банкны төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг.

ЕСБХБ-ны санхүүжилт

25 сая ам.долларын хамтарсан санхүүжилт

Төслийн өртөг

125 сая ам.доллар хүртэлх ам.долларын хамтарсан зээлийн санхүүжилт

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Санхүүгийн байгууллага (FI) гэсэн ангилалд багтсан. ХААН Банк нь ЕСБХБ-ны харилцагчдын нэг бөгөөд тус банкны 2 ба 9-р гүйцэтгэлийн шаардлагуудад (PR) нийцсэн Байгаль орчны бодлого, Байгаль орчин ба нийгмийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шаардлагуудыг бүрэн хангахад шаардлагатай байгаа үйл ажиллагаануудын талаар харилцагчид мэдээллэсэн.

Техникийн хамтын ажиллагаа

Өмнө нь ХААН Банк Монголын Банкуудын төслийн хүрээнд Монгол улсын жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих санхүүжилтийн шугамаар техникийн туслалцаанд хамрагдсан. Тус зээлийг ЕСБХБ-ны Шилжилтийн Эхний Үе дэх Улс Орнуудыг Дэмжих Сан болон ЕСБХБ-ны Хувьцаа Эзэмшигчдийн Тусгай Сангаас санхүүжүүлсэн. Түүнчлэн тус банк үйл ажиллагааны чиглэлээр сонгож авсан улс орнуудын жижиг болон дунд үйлдвэрүүдийг санхүүжилтээр дэмжих багц хөрөнгө оруулалтын хэрэгсэлийн нэг болох дунд үйлдвэрийг хамтран санхүүжүүлэх төслийн техникийн туслалцаанд хамрагдсан. Тус төслийг ЕСБХБ-ны Шилжилтийн Эхний Үе дэх Улс Орнуудыг Дэмжих Сангаас санхүүжүүлсэн.

Техникийн хамтын ажиллагааны сангуудаас санхүүжүүлсэн төслийн зөвлөх үйлчилгээ авах бол [procurement of consultants](#) хэсгээс харна уу.

Компанитай холбоо барих

ХААН Банк ХХК, Сөүлийн гудамж-25, Ш/Х No-192, Улаанбаатар хот-44, , Монгол улс
info@khanbank.com; www.khanbank.com

Утас: +976 11 332333

Факс: +976 70117023

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд эсхүл худалдан авалтын талаарх асуудлаар Харилцагч компанитай холбоо барина уу.

Ерөнхий лавлагаа авах

Худалдан авалттай холбоогүй ЕСБХБ-ны төслийн талаарх лавлагаа авах бол:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

И-мэйл: projectenquiries@ebrd.com

Олон нийтэд мэдээлэх журам (ОНМЖ)

ОНМЖ-д ЕСБХБ-ны баримталж буй стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлэл, ойлголт өгөх зорилгоор мэдээллийг хамааралтай этгээдэд хэрхэн хүргэх болон тэдэнтэй зөвлөх журмыг тодорхойлсон.

[ОНМЖ](#)

Төслийн талаарх санал гомдлын механизм (ТТСГМ)

ЕСБХБ нь хувь хүн эсхүл байгууллагад Банкнаас санхүүжүүлж буй төсөл сөргөөр нөлөөлж буй тохиолдолд тэдэнд хараат бус байдлаар санал гомдол тавих боломж олгох үүднээс Төслийн талаарх Санал гомдлын механизм (ТТСГМ)-ыг бий болгосон. ТТСГМ-ыг зохицуулах журмыг дараах холбоосноос үзнэ үү: www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf, мөн Орос хувилбарыг үзэх бол: <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesr.pdf>-ээс орж үзнэ үү.

ЕСБХБ-аас санхүүжилт олгосноос 12 сарын дотор ТТСГМ-ын дагуу аливаа санал гомдлыг илгээнэ үү. Санал гомдол мэдүүлэх хугацаа тодорхой бус бол энэ талаар ТТСГМ-ыг хариуцсан ажилтан (pcm@ebrd.com гэсэн хаягаар) эсхүл ЕСБХБ-ны төлөөлөгчийн газартай холбогдож мэдээлэл авна уу.

Энэхүү төслийн товч танилцуулгын материалуудыг ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөл тус төслийг авч хэлэлцэхээс өмнө гаргасан болно. Төслийн дэлгэрэнгүй мэдээллүүд нь Төслийн хураангуйг гаргасны дараа өөрчлөгдсөн байж болох бөгөөд энэ нь ЕСБХБ-ны албан ёсны бодлогыг төлөөлөх баримт бичигт тооцогдохгүй болно.

Хамгийн сүүлд 2012 оны 3 сарын 13-ны өдөр шинэчилсэн.